



ИРГЭНИЙ НИСЭХИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2018 оны 06 сарын 13 өдөр

Дугаар А/В/17

Улаанбаатар хот

Ажил хүлээн авах комисс томилох тухай


Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Металл илрүүлэгч гар бээлий 15 ширхэгийг нийлүүлэх ИНЕГ/ЦА/ТББ/Б-19/17 дугаар гэрээт ажлыг хүлээн авах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:

Комиссын дарга:	Б.Алтантуяа	Нисэх буудлуудын бодлого зохицуулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн
Гишүүд:	П.Сүхболд	Худалдан авах ажиллагааны хэлтсийн аэродромын инженер
	Ш.Бямбадорж	“Чингис хаан” Олон улсын нисэх буудлын Аюулгүй байдлын хэлтсийн сургалт, судалгаа хариуцсан мэргэжилтэн
	Д.Оюунсүвд	“Чингис хаан” Олон улсын нисэх буудлын Аюулгүй байдлын хэлтсийн аюулгүй байдлын мэргэжилтэн
	Ц.Дөлгөөн	“Чингис хаан” Олон улсын нисэх буудлын Санхүү нягтлан бодох бүртгэлийн хэлтсийн нягтлан бодогч

2. Дээрх ажлыг техникийн тодорхойлолт, ажлын даалгаврын шаардлагын дагуу шалгаж хүлээн авах, гэрээний хэрэгжилтийг дүгнэн, комиссын акт, холбогдох бусад материалын хамт Худалдан авах ажиллагааны хэлтэст хүргүүлэхийг ажил хүлээж авах Комисс /Б.Алтантуяа/-т даалгасугай.

ДАРГА



Л.БЯМБАСҮРЭН